



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 03 дугаар сарын 30 өдөр Дугаар 27

Хэрлэн сум

ХХVII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 27 дугаар хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 19:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 88,8 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Баянтүмэн гүүрний шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ариутгал халдваргүйтгэл хийх боломжийг судалж танилцуулах,
Мэргэжлийн хяналтын газар

2.Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд нэгдсэн зохион байгуулалттайгаар халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулах тухай танилцуулах,
Мэргэжлийн хяналтын газар

3.Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлэх саналуудыг танилцуулах:

-Сумдын аюулгүйн нөөцөд байршуулах коронавирус илрүүлэх түргэвчилсэн оношлуур худалдан авах санал танилцуулах,
Эрүүл мэндийн газар

-Зочид буудлыг тусгаарлах байраар түрээслэх ашиглах талаар санал танилцуулах
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

-Тээврийн хэрэгсэл түр саатуулах байрны гадна гэрэлтүүлэг, камержуулалт хийх санал танилцуулах,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

-Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт үүрэг гүйцэтгэхэд бэлэн байдлыг хангах зорилгоор зөөврийн цахилгаан үүсгүүр худалдан авах саналыг танилцуулах,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

-Цагаан-Овоо сумын хяналтын цэгт үүрэг гүйцэтгэсэн Цагдаа, Онцгой байдлын алба хаагчдын шатахуун, томилолтын зардлыг танилцуулах,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

-Коронавирусын халдвар бүртгэгдсэн бүсээс Хэрлэн суманд ирсэн ачаа тээврийг буулгах үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан Цагдаа, Онцгой

М.Бадамсүрэн
Д.Баттулга

байдлын алба хаагчдын шатахуун, илүү цагийн урамшууллын зардлыг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

-Улсын аюулгүйн нөөцөөс үнэ чөлөөлөгдсөн өвсийг Хэрлэн сумын 1,2,3,5 дугаар багийн өрхүүдэд тээвэрлэн хүргэхэд шаардагдах зардлыг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

-Халхгол сумын Цагдаагийн тасгийн автомашины засварт шаардлагатай зардлыг танилцуулах,

Цагдаагийн газар

-Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ашиглах зорилгоор автобус 2 ширхэгийг худалдаж авах санал танилцуулах,

Авто тээврийн төв

4.Аймгийн аюулгүйн нөөцөөс малчдад үнэ чөлөөлж өвс тэжээл олгох тухай хэлэлцэх,

Хүнс, хөдөө аж ахуйн газар

5.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичиг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

1.1.Ариутгал халдваргүйтгэл хийх 2 ширхэг мананцаржуулах төхөөрөмжийг худалдаж авахад шаардагдах зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа нарт:



1.2.Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ариутгал халдваргүйтгэл хийх ажилд албан хаагч нарыг томилгоожуулах,

Хоёр.Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-д:

2.1.Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд нэгдсэн зохион байгуулалттайгаар ариутгал халдваргүйтгэл хийх төсвийн тооцоог гаргаж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

Гурав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

3.1.Бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор аймаг, сумын аюулгүйн нөөцөд байршуулах коронавирус илрүүлэх 700 ширхэг оношлуур худалдан авахад

 / М.Бадамсүрэн
 / Д.Баттулга

шаардагдах зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах, Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

3.2."Дулаан" дэн буудлыг тусгаарлах байраар ашиглаж түрээслэхэд шаардагдах зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.3.Тээврийн хэрэгсэл түр саатуулах байрны гадна камержуулалт 3,000,000 төгрөг, гэрэлтүүлэг хийхэд шаардагдах 4,658,000 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

3.4.Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт үүрэг гүйцэтгэхэд бэлэн байдлыг хангах зорилгоор 2 ширхэг зөөврийн цахилгаан үүсгүүр худалдан авахад шаардагдах 3,300,000 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

3.5.Аймгийн Онцгой комисст зарцуулсан липтэн цай 132 ширхэг, цэвэр ус 102 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газарт олгох,

3.6.Цагаан-Овоо сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгт Цагдаа, Онцгой байдлын алба хаагчдын үүрэг гүйцэтгэхэд шаардагдах зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

3.7.Чойбалсан хотод хүнс ачаа тээвэр буулгах үед хяналт тавьж ажиллахад шаардагдах зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

3.8.Улсын аюулгүйн нөөцөөс үнэ чөлөөлөгдсөн өвсийг Хэрлэн сумын 1,2,3,5 дугаар багийн өрхүүдэд тээвэрлэн хүргэхэд гарсан 764,000 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг-г:

3.9.Халхгол сумын Цагдаагийн тасгийн автомашиныг засварлахад шаардагдах 3,290,000 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:

3.10.Коронавируст халдвар /COVID-19/-ын илрүүлэг шинжилгээ хийх зөөврийн хяналтын цэгээр ашиглах 2 ширхэг автобус худалдан авах, тохижуулахад гарах зардал 30,000,000 төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах,

1.02


/М.Бадамсүрэн
Д.Баттулга

Дөрөв.Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ж.Алимаа-д:

4.1.Аймгийн аюулгүйн нөөцөд байгаа 8615 боодол өвсийг иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор үнэ чөлөөлж иргэдэд тусламжаар олгохыг зөвшөөрөв,

АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Гаалийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Б.Гэрэлт-Од,
Хилийн 0198 дугаар ангийн захирагч, хурандаа Б.Гантөгс нарт:

5.1.“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Хилийн Баянхошуу боомтоор тусгай тоноглол бүхий техник, багаж хэрэгслийг нэвтрүүлэх тухай” хүсэлтийн дагуу судалж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА